



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/206

Улаанбаатар хот

Л.Булганд чөлөө олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албаны Тохижилт, Хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Лхамдашийн Булган Америкийн нэгдсэн улсад зохион байгуулагдах Скаутын дэлхийн 24 дүгээр цугларалтад Монгол улсаа төлөөлж оролцож, зэрэг ахиулах сургалтад хамрагдах болсон хүсэлтийг нь харгалзан дотоод журмын 6 дугаар бүлгийн 6.16-д заасны дагуу 2019 оны 07 дугаар сарын 29-нөөс 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийг хүртэлх хугацааны ажлын 12 хоногт цалингүй чөлөө олгосугай.

2. Л.Булганы ажлыг орлон ажиллах хуваарийн дагуу холбогдох мэргэжилтэнд хүлээлцүүлж, эзгүй байх хугацаанд нь ажил үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Г.Ууганбаярт даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

